

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ЭРСДЭЛИЙГ СААРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
БУЮУ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2025 оны 06 дугаар сарын 09

Улаанбаатар хот

Д/д	Байгууллага дотооддоо арилган бууруулж, урьдчилан сэргийлж болох эрсдэл	Эрсдэлийг сааруулах хариу арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5
Нэг. Хэрэгцээ, шаардлага буюу төсөв, санхүүгийн чиглэлээр				
1	Хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал хүрэлцэхгүй байх, санхүүгийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх	Төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан 2026 оны төсвийн төслийг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад уламжлан Сангийн яаманд хүргүүлэх Батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах санал, тайлбарын хамт Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэн шийдвэрлүүлэх Дотоод аудит, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2026 оны төсвийн хязгаарт тусгах саналыг урт хугацааны бодлогын баримт бичиг, төв болон орон нутаг дахь нэгжүүдийн саналыг үндэслэн авлага, өглөг үүсгэхгүй үр дүнтэй байхаар тооцон боловсруулж, тайлбар, танилцуулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1016 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн энэ оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 01/490, 01/813, 01/1015 дугаар албан бичгээр 3 удаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, холбогдох зарим зардлыг шийдвэрлүүлсэн. Дотоод аудитын энэ оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Хойд бүс дэх газрын захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт шалгалт, 01-08/04 дүгээр удирдамжийн дагуу Өмнөд бүс дэх газрын энэ оны 01-05 дугаар сарын санхүү, нийцлийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, мэргэжил, арга зүйгээр ханган, үр дүнг удирдлагад танилцуулж ажилласан.	90%
Хэсгийн дундаж: 90%				
Хоёр. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын чиглэлээр				
2	Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг харьяатаас гаргахыг шаардах, аль нэг улсынхаа иргэний харьяаллаа сонгохыг тулгах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс хоёрдмол харьяалалтай иргэд нэмэгдэх	Хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулах, шалгалтаар илэрсэн хоёрдмол харьяалалтай Монгол Улсын иргэдийн мэдээллийг нэгдсэн санд бүрэн гүйцэд оруулах Хүний эрхийг дээдлэн, эрх зүйн зохицуулалтыг тодорхой ойлгомжтой болгох талаар холбогдох дээд шатны байгууллагад хүсэлт хүргүүлэх	Байгууллагын даргын 2009 оны “Хоёрдмол харьяалалтай иргэдийн бүртгэл, судалгаа хөтлөх тухай” 275 дугаар тушаалын дагуу хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг илрүүлсэн даруй тогтмол бүртгэлжүүлэн ажиллаж байна. Гадаадын иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 53 улсын 5055 иргэн бүртгэлтэй байгаагаас тайлант хугацаанд 52 иргэнийг бүртгэжээ. Монгол Улсын харьяатаас гаралгүй БНКаЗУ-ын иргэний харьяаллыг аван хоёрдмол харьяалал үүсгэсэн 1175 иргэний халамж, нийгмийн даатгал, сонгуульд оролцож байсан эсэх талаарх судалгаа гаргах зорилгоор УБЕГ, ХХҮЕГ, НДЕГ-т албан бичиг хүргүүллээ.	90%

Д/д	Байгууллага дотооддоо арилган бууруулж, урьдчилан сэргийлж болох эрсдэл	Эрсдэлийг сааруулах хариу арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5
			Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, тандалт судалгааны тайланг 03 дугаар сарын 21-ний өдөр удирдлагад танилцуулсан. Уг хуулийн төсөл нь 04 дүгээр сарын 09-ний өдөр “lawforum.parliament.mn” цахим хуудасны боловсруулж буй төслүүд цэсэд байршсан бөгөөд УИХ-ын гишүүн П.Сайнзориг Засгийн газраас санал, дүгнэлт авч, УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	
3	Нийтээр амрах баярын өдөр болон 7 хоног бүрийн амралтын өдөр, эсхүл ажлын бус цагаар гадаадын иргэний зөрчлийг илрүүлэн түр саатуулах тохиолдолд жижүүрийн шүүгч байдаггүйгээс Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа удаашрах	“Зөрчлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг холбогдох дээд шатны байгууллагад дахин хүргүүлэх	Хууль зүй, дотоод хэргийн сайдын энэ оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/1631 дугаартай албан бичгээр Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт хэрэглэх журам”, “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт шинэчлэн батлах” тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/675 дугаар албан бичгээр хариу хүргүүлэв. Монгол Улсын Их хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр шинэчлэн баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3-т зааснаар Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх байгуулахаар тусгасан бөгөөд уг шүүх эрүүгийн болон зөрчлийн хэрэг, таслан сэргийлэх арга хэмжээг харьяалан хянан шийдвэрлэхээр 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлд зааснаар гадаадын иргэнийг саатуулах буюу таслан сэргийлэх арга хэмжээг энэхүү шүүх харьяалан шийдвэрлэж, шүүн таслах үйл ажиллагаа ажлын өдөр бүрийн 22.00 цаг хүртэл тасралтгүй хэрэгжихээр зохион байгуулсан байна.	70%
Хэсгийн дундаж: 80%				
Гурав. Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын чиглэлээр				
4	Алслагдсан хилийн боомтод ажиллаж, амьдрах орчин нөхцөл бүрэн хангагдаагүйгээс	Тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломжийг хангах талаар шат дараатай арга хэмжээ авах	Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн төрийн тусгай болон төрийн үйлчилгээний нийт 151 албан хаагчийн албан тушаалын үндсэн цалинг байгууллагын даргын 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/12 дугаар тушаалаар	100%

Д/д	Байгууллага дотооддоо арилган бууруулж, урьдчилан сэргийлж болох эрсдэл	Эрсдэлийг сааруулах хариу арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5
	ажиллах тогтворгүй байдал үүсэх		нэмэгдүүлэн шинэчлэн тогтоолоо. Байгууллагын хэмжээнд 42 удаагийн дотоод сургалтад давхардсан тоогоор 1800 гаруй албан хаагч хамрагдсанаас Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад төвийн 3, орон нутгийн 7 албан хаагч хамрагджээ. БНСУ, Филиппин, БНЭУ, Унгар Улсад төвийн 13, орон нутгийн 4 албан хаагч сургалт, арга хэмжээнд хамрагдсан. Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04/05 дугаар тогтоолын хүрээнд тус газрын 2 албан хаагчийн орон байрны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, Зүүн бүс дэх газар албан хаагчдын амьдрах 3 өрөө орон сууцыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлжээ. Хойд бүс дэх газрын албан хаагчдыг чадавхжуулах орчин үеийн чанар стандартад нийцсэн цогц сургалтын төвийн байр зүйн зургийг Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай хамтран 03 дугаар сарын 21-ний өдөр хийж, “Мон Арч Констракшн” ХХК-иар зураг төслийн ажлыг гүйцэтгүүлж, загвар зургийг Сэлэнгэ аймгийн Онцгой байдал, Эрүүл мэндийн газарт хянуулахаар хүргүүлжээ. Дорноговь аймаг дахь газар албан хаагчдын бялдаржуулах өрөөг 05 дугаар сард засварлан тоног төхөөрөмж суурилуулан тохижуулж, Говьсүмбэр аймаг, Ханх, Ханги боомтын албаны болон амьдрах байрны зарим тавилгыг шинэчилж, урсгал засвар хийсэн байна.	
5	Хадгаламжийн нэгжүүд цаасан баримтад байгаа тохиолдолд эрсдэл бий болсноор нөхөн сэргээгдэх боломжгүй тул цахим хэлбэрт шилжүүлэх, хортон шавж, мэрэгч амьтдаас урьдчилан сэргийлэх	Цаасан суурьтай байнга хадгалах баримтыг эрсдэлээс хамгаалах зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх, хортон шавж, мэрэгчийн устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэх	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, байгууллагын даргын 2023 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Цахим баримт бүрдүүлэх, хөтлөх, архивд шилжүүлэх журам”-ын дагуу энэ оны эхний хагас жилд байнга хадгалах 51 хадгаламжийн нэгжийн 12718 хуудас баримтыг PDF хэлбэрээр 23 ширхэг дискт хуулбарлаж, цаасан суурьтай баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, баримтын эх хувийг ашиглалтаас чөлөөлөх арга хэмжээ авсан. Төвийн байранд байрлах А, Б хадгаламжийн санд “Болор ариусгал” ХХК-иар 05 дугаар сарын 26-ны өдөр хортон шавж устгалын ажил хийлгэж, архивын баримтыг эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч ажиллалаа.	100%

Д/д	Байгууллага дотооддоо арилган бууруулж, урьдчилан сэргийлж болох эрсдэл	Эрсдэлийг сааруулах хариу арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5
Хэсгийн дундаж: 100%				
Дөрөв. Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн чиглэлээр				
6	Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар холбогдох байгууллагатай хамтран баталсан төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийн ажиллах, мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах	Байгууллагын гамшгаас хамгаалах орон тооны бус штаб болон бүлгүүдийг байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/594 дугаартай тушаалаар шинэчлэн баталсан. Гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүд аймгийн Онцгой байдлын газартай хамтран баталсан гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 2025 онд тодотгол хийж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Байгууллагын даргын энэ оны 01-02/27 дугаар удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар ангитай хамтран 05 дугаар сарын 14-ний өдөр Гамшиг эрсдэлийн үед авах арга хэмжээ сэдэвт сургалт зохион байгуулсан. Мөн байгууллагын 80 албан хаагчийг цуглах цэгт цагт нь цуглуулж, хувцас, аранз зэрэг бэлэн байдлыг хангуулан ажиллаж, энэ талаар Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны Засаг даргад хүргүүлэн ажилласан. Хойд бүс дэх газар 02 дугаар сарын 19-ний өдөр Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар, Улаан Загалмайн хорооны салбар нэгжтэй хамтран “Ой хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах”, “Зүрх, уушгины сэхээн амьдруулалд” сэдэвт, Зүүн бүс дэх газар 04, 05 дугаар сард “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголт”, “Эрсдэлийн үнэлгээ хэрхэн хийх, зааварчилга хэрхэн өгөх тухай” сургалтыг зохион байгуулжээ. Зүүн бүс дэх газар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар 02 дугаар сарын 18-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг мэргэшсэн багштай байгуулж, бүсийн төвд эрсдэлтэй ажлын байранд ажилладаг албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, хилийн Бичигт, Эрээнцав боомтод эрсдэлийн үнэлгээ хийлгүүлсэн. Хойд бүс дэх газар 05 дугаар сард Сэлэнгэ аймгийн зарим сумдад	90%

Д/д	Байгууллага дотооддоо арилган бууруулж, урьдчилан сэргийлж болох эрсдэл	Эрсдэлийг сааруулах хариу арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5
			гарсан түймрийн голомтод ажиллаж буй Онцгой байдлын албан хаагчид, аймгийн Онцгой комиссын гишүүдэд “EcoFlow” генераторын цэнэглэгч төхөөрөмжийг хүлээлгэн өгч, гамшгийн эсрэг бэлэн байдалд ажилласан.	
7	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) систем хэвийн ажиллагаа алдагдах, мэдээллийн сан устах, гэмтэх үед дахин сэргээгдэхгүй байхаас урьдчилан сэргийлэх	Хэрэглэгчийн системд хандах эрх, төхөөрөмжийг бүртгэлжүүлэх эрхийн тохиргоо хийх Давхар ажиллагааны зарчмаар ажиллах сервер тохируулах Систем дээр ажиллах журам батлуулан дагаж мөрдөх	Кибер аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох журмын дагуу системийн хэвийн үйл ажиллагааг хангахаар нөөцлөлтийг өдөр бүр тогтсон хугацаанд авч ажиллаж байгаа бөгөөд системд хандсан албан хаагчийн лог бүртгэлийн хөгжүүлэлтийг хийж байна. Байгууллагын даргын 2025 оны А/168 дугаар тушаалаар “Кибер аюулгүй байдлыг хангах журам”-ыг баталж, мөрдөн ажиллаж байна.	70%
8	Цахилгаан эрчим хүч, ус дулааны доголдол, гадны нөлөөллөөс шалтгаалан бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан эвдрэх, сүлжээний техник хэрэгсэлд саатал учирч тасалдсанаар механик ажиллагаа явагдаж, үйл ажиллагааны ачаалал нэмэгдэж, мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдал алдагдах	Цахилгаан эрчим хүч, ус дулааны доголдол, гадны нөлөөллөөс болж үүсэх эрсдэлээс сэргийлэн нөөц аваарын төхөөрөмж, багаж хэрэгслийг бэлэн байлгах	Байгууллага сүлжээний тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор суурин 20, явуулын хяналт шалгалт хийх 8 цэгт ашиглагдах сансрын холбооны старлинк төхөөрөмжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр “Мобинет” ХХК-тай ГИХГ/20250103005 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн ГИХГ/20240102010 дугаар тендер шалгаруулалтаар аваарын үед ашиглагдах 26 ширхэг серверийг 05 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авч, ашиглахад бэлэн болгосон. Цахилгааны тасалдлын үед ашиглагдах 75 кВт-ийн 2 ширхэг цахилгаан мотор хүний оролцоогүй автоматаар сэлгэлт хийн бэлэн байдалд ажиллаж байна. Баруун бүс дэх газар мэдээллийн сүлжээ тасалдах, шилэн кабелийн шөрмөсний гэмтэл гарсан үед ашиглах зорилгоор нэмэлт шөрмөсийг цэнэглэж бэлэн байдалд бэлтгэн, барилгад суурилуулсан дохиоллын системд нэмэлт цахилгааны эх үүсвэрийн баттерэйг байрлуулсан. Өмнөд бүс дэх газар серверийн өрөөнд цахилгааны тэжээлийн тасалдал үүсэх, хэлбэлзэхээс урьдчилан сэргийлж, сүлжээний тог баригчийг суурилуулан хаалганы цоожийг хүний давхцахгүй өгөгдлөөр онгойх ухаалаг цоожоор сольсон байна. Зүүн бүс дэх газар хилийн Хавирга, Ульхан боомтын ажлын байранд цахилгааны аюулгүйн нөөц мотор байршуулсан.	70%
Хэсгийн дундаж: 77%				

Д/д	Байгууллага дотооддоо арилган бууруулж, урьдчилан сэргийлж болох эрсдэл	Эрсдэлийг сааруулах хариу арга хэмжээ	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5
Нийт үнэлгээ: 87%				

---oOo---